

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

а/ Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр: ГХУСАЗЗ-ийн ээлжит хуралдаан 2021 оны 10 сарын 22-ны өдрийн 10 цагт хуралдаж 2 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. Хэсгийн төлөөлөгч Х.Батэрдэнэ 2021 оны ГХУС ажил, сумын цагдаагийн хэсгийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл
2. Зөвлөлийн гишүүдийн саналыг сонсох, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцох

2021 оны 10 сарын 23-27ны хооронд БИНХ-ын товыг зарлан хуралдааны үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

АИТХ-ын даргын захирамжийн дагуу 2021 оны сумдын ИТХ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шинжилгээ хийх ажлын хэсэг 10 сарын 25-ны өдөр ирж ажиллалаа.

ГХУС ажлын чиглэлээр сумын насан туршийн боловсролын багш М.Дуламжаргалтай хамтран аймгийн насан туршийн боловсролын төвийн багш Уянгаар сумын төрийн албан хаагчдын дунд Угийн бичиг хөтлөх цахим сургалтыг зохион байгуулсан.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр: 10 дугаар сарын 1 ний өдөр Ахмадын баяр тохиож буйтай холбогдуулан ахмадын хорооноос зохион байгуулсан цахим хуралд ахмадын төлөөлөл болох 10 ахмад оролцлоо. Мөн төрийн дээд олон медаль авсан 3 иргэнд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулж ажиллалаа. ЗДТГ аас өндөр насны тэтгэвэрт гарсан 6 ахмадад хүндэтгэл үзүүлж мөн гарын бэлэг гардуулж ажиллав.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний эцсийн шатны хэлэлцүүлэгийг 10 дугаар сарын 16 ны өдөр ЕБС ийн спорт зааланд зохион байгуулж ажиллалаа.

Ковид-19 өвчнөөр нас барсан иргэнийг оршуулах ажлыг зохион байгуулж тайлан мэдээг аймгийн МХГ-т хүргүүлэв.

Хоёр дугаар ээлжийн цэрэг татлагын комиссын үзлэгийг суманд зохион байгуулж нийт цэргийн насны 73 иргэнийг хамруулж цэргийн жинхэнэ албанд 5 иргэн, мөнгөн дүйцүүлэхээр 4 иргэн цэргийн алба хааснаар тооцуулав.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

Авилгатай тэмцэх газраас 10 дугаар сарын 1 ний өдөр 2021 онд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан “Авилга, авилгын хор хөнөөл, шалтгаан нөхцөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, Төрийн албан хаагчдын ёс зүй” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтад 2021 онд шинээр томилогдсон 3 албан хаагч хамрагдав.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хүүхдийн цэцэрлэг: Ахмадын баяраар байгууллагынхаа өндөр насны тэтгэвэрт гарсан 6 ахмадыг хүлээн авч гарын бэлэг гардуулсан.

Гадна талбайд тарьсан хүнсний ногоог хураан авч хүүхдийн хүнсэнд хэрэглэж байна. Төмс 40 кг, огурцы 18 кг, помидор 12 кг, лууван 8 кг, манжин 7 кг, хүрэн манжин 11 кг хураан авсан.

Бүлгүүдэд 7 ш сургалтын тавиур хийж, хүүхдийн сурах ая таатай нөхцөлийг ханган ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургууль: Ахмадын баяраар байгууллагынхаа өндөр насны тэтгэвэрт гарсан 12 ахмадыг хүлээн авч гарын бэлэг гардуулсан.

Ковид – 19 өвчний дэгдэлт ихэсч байгаатай холбогдуулан байгууллагынхаа багш ажилдчын дархлааг дэмжин ажиллаж байна.

Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулж буй “Сургуульд суурилсан үнэлгээ” шалгалтыг 3-9р ангиас нийт 17 төрлийн хичээлээр шалгалт авч үнэлгээ дүгнэлтийг хийн ажиллаж байна.

Нийгмийн ажилтан АУБ нартай хамтран хүүхэд хамгааллын чиглэлээр 6-н төрлийн судалгааг хийж эрсдэлт нөхцөлд байгаа, хүчирхийллийн дарамтанд байгаа сурагчдыг судлан оношилсон.

Сургуулийн нийт сурагчдыг сумын ЭМТ-тэй хамтран үзлэгт оруулсан.

Нийт багш ажилчдын 87.5% нь вакцины 3-р тунд хамрагдсан.

Өнөөдрийн байдлаар 3 бүлэг цахимд шилжиж 7 бүлэг танхимаар үйл ажиллагаагаа явуулж хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Соёлын чиглэлээр: Монголын ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 болон байгууллагын дотоод журмын 9.3 заалтуудыг үндэслэн соёл урлагийн байгууллагаас өндөр настны тэтгэвэрт гарсан ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг өглөө.

Мэргэжлийн хяналтын газрын ээлжит шалгалт энэ 10 дугаар сард болж манай байгууллагын барилгын хэвийн байдал болон дотоод үйл ажиллагааг шалгаж заавар зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан бөгөөд үнэлэлт дүгнэлт сайн гэж дүгнэгдлээ.

Сумын багуудын өдөрлөгт соёлын үйл ажиллагааныхаа талаар мэдээ мэдээлэл өгч ажиллаж байна

Ахмадын баяраар төрийн дээд одон медаль гардуулах ёслолын арга хэмжээний нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

Номын сангийн үйл ажиллагааны хүрээнд: Номын сангийн хувьд энэ сард сумын Шинээр ирсэн номнуудыг Халзан сум Соёлын төв гэсэн фээж хуудсаар

дамжуулан уншигч үйлчлүүлэгч нартаа танилцуулан гэрээр ном олгох үйлчилгээг үзүүлж байна.

Багуудын өдөрлөгөөр явуулын номын сангаа ажлуулж уншигч үйлчлүүлэгч нартаа шинээр карт нээж ном олгох үйлчилгээг үзүүлж ажиллаж байна. Мөн Угийн бичгийг өрх бүрээр хөтлүүлэх арга хэмжээнд зориулж иргэдэд гарын авлага зөвлөмжийг хүргэн ажиллалаа.

Хөдөлмөр халамжийн чиглэлээр: 2021 оны 10 дугаар сарын 1, 2 –нд “Алсын Оч Оптик” ХХК Нүдний эмнэлэг хараа зүйн газар Халзан суманд 2 өдрийн турш Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Хөдөлмөр халамжийн тухай хуульд зааснаар харааны шил хийж үйлчилсэн. Халзан сумын хэмжээнд Ахмад настан 51, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3 нийт 54 иргэн үнэ төлбөргүй харааны шил хийлгэсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлийг хийж Байнгын асаргааны ахмад настан 3 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сунгалт 1, Байнгын асаргааны сунгалт түдгэлзүүлсэн 1, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхөөс түдгэлзүүлсэн 1 өрх, 1 иргэн, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн төсөлд 1 төсөл хэлэлцсэн.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Дэд дарга Б. Сонинбаяраар ахлуулсан ажлын хэсэг Халзан суманд Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн эргэн төлөлтийн хугацаа хоцролтонд хяналт хийж албан бичиг хүргүүлж ажилласан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж буй “Эрдэнэ ЗММ” ХХК-д хүнсний эрхийн бичгийн хүнсний бараа олголт цахимд шилжиж программын шинэчлэлт хийж байгаа тул 10 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний бар кодыг программд таниулах хөгжүүлэх ажлыг хийж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: 10 дугаар сард нийт батлагдсан тохиолдол болох 105 иргэнийг эмнэлэгт эмчилж ажиллаж байна. Улаан бүсэд 1 их эмч, 1 сувилагч, 1 үйлчлэгч 14 хоноод 2 дахь ээлжийн 1 бага эмч, 2 үйлчлэгч 2 сувилагч ажиллаж байна. Тандалтын 2 баг ажиллаж, батлагдсан иргэдийн ар гэрийн ойрын хавьтал тогтоох, ариутгал халдваргүйтгэл хийх ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Нийт 240 иргэнээс түргэвчилсэн шинжилгээ авч ажилласан. Одоогийн байдлаар сумын эмнэлэгт 46 хүн хэвтэн эмчүүлж байгаагаас 1 хүний биеийн байдал хүндэвтэр, 1 хүн сэжиглэн эмчлэгдэж, 48 хүн хөнгөн байна. Үүнээс 9 хүүхэд байна, жирэмсэн байхгүй.

Мал эмнэлэгийн чиглэлээр: Халзан сумын 2-р багийн Талын хашаат гэдэг газарт нутагладаг 3-р багийн малчин Ж.Ганболдын хотонд Үхрийн арьс товруутах өвчин оношлогдож сумын засаг даргын А/128 тоот хязгаарлалтын дэглэм тогтоож, Улсын мал ариун цэврийн лабораторын 21-4044 бүртгэлийн дугаартай шинжилгээний хариуг үндэслэн сумын засаг даргын А/129 тоот Хорио цээрийн дэглэм тогтоож өвчилсөн 10 малыг устгалд оруулсан.

Голомтын бүст байгаа 10 айлын 1000 мал урьдчилан сэргийлэх тарилганд хамрагдаж , 13 өрхийн 15200мкв талбайд ариутгал хийж, 1052 үхрийг угаалганд хамруулаад байна.

Сумын төвийн хэмжээнд урьдчилан сэргийлэх зорилгоор 55 өрхийн 1320 үхрийг угаалганд хамруулаад байна.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 25970 хурга ишиг, 1859 тугал хамрагдаж мал эмнэлгийн цахим системд тулгалт хийж тааруулаад байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын ажилтан Цэнд, Мал эмнэлгийн газрын албаны дарга Сундуй нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Онгон халзан сумын голомтын бүсэд авсан арга хэмжээтэй танилцаж үнэлэлт дүгнэлт өгсөн.

Аймгийн мал эмнэлгийн газраас сумдын байцаагч нарт прокороороос Роза ирж мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, зөрчлийн тухай хууль, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх , хэрэг нээх талаар сургалт зохион байгууллаа.

Байгаль орчны чиглэлээр: БОАЖГ-ын 3550 000 төгрөгийн санхүүжилтээр 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “ Баян булаг” –ийн эхийг хашиж хамгаалав.

Намрын мод тарих үндэсний өдрөөр “Тал хээрийн зэрлэг амьтан судлалын төв” өөрийн эзэмшил газартаа шинээр 1000 суулгац суулгасан

Албан газар аж ахуйн нэгжүүд өөрийн газарт тарьсан модондоо цэнэг усалгаа хийв. Албан газар аж ахуйн нэгж байгууллагын модонд тооллого явуулж хавар тарьсан модны ургалтын хувийг тогтоов.

Золбин нохой устгах ажлыг зохион байгуулж нийт эзэн холбогдогчгүй 14 нохой устгаж ариутгал халдваргүйжилтыг хийж гүйцэтгэлээ.

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтыг хангуулах тухай Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 02 тоот албан даалгаварын өиелэлтийг гаргаж Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэв.

Багийн засаг дарга нарт байгаль орчныг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах талаар яриа таниулга хийлээ

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
МЭРГЭЖИЛТЭН

Д.ДАЙРИЙМАА

ХАРИУЦСАН

